



ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН  
БАЙГУУЛЛАГУУДАД

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 81 69,  
Цахим хуудас: [www.mmhi.gov.mn](http://www.mmhi.gov.mn)

2023.11.13 № 03/2759

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хамтран ажиллах тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д “Цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурьлагдсан хүчин чадлыг өргөтгөх, тухайн шинэ эх үүсвэрийг цахилгаан дулаан хангамжийн системд холбох шугам болон дагалдах дэд бүтцийн ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно” гэж, тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.21-д “Засгийн газраас энэ хуулийн 40.5-д заасны дагуу тогтоосон төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлнө” гэж тус тус заасан.

Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоолоор батлагдсан “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ын 3.4-т “Эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн импортоор оруулах бараа нь түүний үндсэн хөрөнгөд бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй тоног төхөөрөмж байна. Дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй тоног төхөөрөмжийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тодорхойлно” гэж заасны дагуу эрчим хүчний салбарт ашиглагддаг тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, бүтээгдэхүүний мэдээлэл авах тухай хүсэлтийг Эрчим хүчний яамнаас ирүүлээд байна.

Иймд танай байгууллагын үйлдвэрлэдэг эрчим хүчний салбарт ашиглагддаг чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны нэр, төрлийн жагсаалтыг тухайн барааны товч тодорхойлолт (зориулалт, үйлдвэрлэлийн хэмжээ), итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээний хуулбарын хамт 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн дотор албан бичгээр болон цахим ([oyunbold@mmhi.gov.mn](mailto:oyunbold@mmhi.gov.mn)) хаягаар ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

1508 04 2328